


**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗДТГ-ЫН 2021 ОНЫ АВЛИГЫН  
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

- Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар
- Эрх бүхий албан тушаалтан 99599658, 88599658
- 2021 оны 12 дүгээр сарын 13

№	Хөтөлбөрийн танилцуулга хэсэг	
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, МУ-ын Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улс, орон нутгийн хөрөнгө оруулалт
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага
5.	Хэрэгжих нийт хугацаа	1 жил
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p><b>Зорилго 1.</b> Авлигатай тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p><b>Зорилго 2.</b> Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох;</p> <p><b>Зорилго 3.</b> Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх;</p> <p><b>Зорилго 4.</b> Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах;</p> <p><b>Зорилго 5.</b> Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх;</p> <p><b>Зорилго 6.</b> Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх;</p> <p><b>Зорилго 7.</b> Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах;</p> <p><b>Зорилго 8.</b> Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах;</p> <p><b>Зорилго 9.</b> Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх;</p> <p><b>Зорилго 10.</b> Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах;</p> <p><b>Зорилго 11.</b> Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох;</p> <p><b>Зорилго 12.</b> Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/ гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах;</p> <p><b>Зорилго 13.</b> Тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил тод, нээлттэй болгох;</p>

		<b>Зорилго 14.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах; <b>Зорилго 15.</b> Авлигын эсрэг санал санаачилгыг дэмжин ажиллах;	
7.	Зардал	Төсөв	10.0 сая.төг
		Үүнд:	Төсөв
		Үе шат	Гүйцэтгэл
<b>Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг</b>			
8.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Гүйцэтгэлийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ болон аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн баталсан Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээ	
	Нэг. Авлигатай тэмцэх урьдчилан сэргийлэх арга боловсруулж хэрэгжүүлэх;	<p><b>1.1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулан батлуулж, хэрэгжилт үр дүнг хурал зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлүүлж тайлагнах.</b></p> <p>Аймгийн ЗДТГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээг Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн загварын дагуу 15 зорилго, 65 арга хэмжээг төлөвлөн боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг Олон улсын авлигын иргэд, олон нийтэд байгуулагдсан үйл танилцуулан, 91.7 хэрэгжилттэй Авлигатай тэмцэх газарт тайлагналаа.</p>	  <p>эсрэг өдөр зохион ажиллагаа хувийн программаар хүргүүлэн</p> <p><b>100 хувь</b></p>
	Хоёр. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох;	<p><b>1.2.Батлагдсан төлөвлөгөөг сум, байгууллагуудад хүргүүлж, танилцуулах арга хэмжээг зохион байгуулах.</b></p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад дүгнэх хуудасны хамт хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар семинар, сургалтыг зохион байгуулав.</p>	 <p><b>100 хувь</b></p>
		<p><b>2.1.Удирдлагаас гаргасан төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад шийдвэр /тушаал, захирамж/-ийг цахим хуудсандаа байршуулах.</b></p> <p>Аймгийн Засаг даргаас батлан гаргасан 402 захирамж, аймгийн ЗДТГ-аас баталсан 171 тушаал шийдвэрийг <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтны Эрх зүйн акт хэсэгт тус тус байршуулан сурталчлан таниулж, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулав.</p>	 <p><b>100 хувь</b></p>
		<p><b>2.2.Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн талаарх судалгаа хийж, үр дүнг үйл ажиллагаандаа ашиглах.</b></p>	

Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас 2021 оны нэгдүгээр сард ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн судалгааг 3 бүлэг, 16 асуулгаар авахад албан хаагчдын ерөнхий сэтгэл ханамж 76,05 хувьтай байсан. Санал асуулгын дүгнэлтэд үндэслэн 3 чиглэлийн хүрээнд 15 арга хэмжээний төлөвлөгөө батлуулан ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэх санал асуулгыг 11 дүгээр сард албан хаагчдаас авч дүнг харьцуулахад албан хаагчдын сэтгэл ханамж 4.6 хувиар өссөн үр дүнтэй байна.

**70 хувь**

**2.3. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах.**

Архивын ерөнхий газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн А/24 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г тогтоосон тарифаар иргэд, үйлчлүүлэгчдээс төлбөр хураамжийг арилжааны банкуудад тушаалган баримтыг үндэслэн үйлчилж байна. Уг тарифны мэдээллийг [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтны Эрх зүйн акт хэсгийн Хууль тогтоомж, дүрэм, журам хэсэгт байршуулан сурталчилж таниуллаа.

Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ

№	Үйлчилгээний төрөл	Хүлээгдэж буй үйлчилгээний хугацаа	Үйлчилгээний хөлсний хэмжээ (төг)
1	Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ		
1	1.1 Үйлчилгээний төрөл	2	3
1	1.1.1 Үйлчилгээний төрөл	5 өдөр хүртэл	3.000
1	1.1.2 Үйлчилгээний төрөл	10 өдөр хүртэл	6.000
1	1.1.3 Үйлчилгээний төрөл	15 өдөр хүртэл	10.000
1	1.1.4 Үйлчилгээний төрөл	20 өдөр хүртэл	15.000
1	1.1.5 Үйлчилгээний төрөл	30 өдөр хүртэл	20.000
2	2.1 Үйлчилгээний төрөл	15 өдөр хүртэл	2.500
2	2.2 Үйлчилгээний төрөл	10 өдөр хүртэл	2.000
2	2.3 Үйлчилгээний төрөл	5 өдөр хүртэл	1.500
2	2.4 Үйлчилгээний төрөл	3 өдөр хүртэл	1.000
2	2.5 Үйлчилгээний төрөл	1 өдөр хүртэл	30.000

**100 хувь**

**2.4. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах.**


Захиргааны ерөнхий хуулийн 26, 27 дугаар зүйлийг баримтлан аймгийн Стратеги төлөвлөгөө, Хүний нөөцийн хөтөлбөр боловсруулахаар [Dundgovi.gov.mn](http://Dundgovi.gov.mn) цахим хаягаар иргэдээс санал, хүсэлтийг хүлээн авч хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 дүгээр “Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоог дэмжих тухай” захирамжаар аймаг, сумдын Засаг дарга нар аймаг, сумдын бүтээн байгуулалт, дэд бүтэц, байгаль орчин, нийгмийн салбарын хөгжилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Бямба гаригт иргэдтэй тусгайлан уулзаж тэдний санал, хүсэлтийг сонсох, шийдвэрлэх, идэвх санаачлагыг дэмжих, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. “Сумдын удирдах ажилтан, албан хаагчийн зөвлөлдөх уулзалт, сургалт”-ын үеэр сумдын Засаг дарга нарт хуулиар тусгайлан олгогдсон эрх хэмжээний хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг батлуулах шийдвэрүүдийн талаар сургалт, семинар зохион байгууллаа. 2021 оны эхний хагас жилийн байдлаар Луус, Өлзийт, Дэлгэрцогт сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын батлан гаргасан “Малын тоо толгойн албан татварын хэмжээг тогтоох тухай” 3 эрх зүйн актыг улсын нэгдсэн санд бүртгүүллээ.

**70 хувь**

Гурав. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх;

**3.1. АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх.**

Шударга ёсны үнэ цэнэ, Авлигын эсрэг олуулаа нэгдье, Гэрэл тусгая Зш, Арын хаалга, Албаны мэдээллээ аминдаа, Гайтай бэлэг, Танилын бөмбөлөг, Авлига Төрийн албан хаагч дугаарын сурталчилгаа Дундговь аймгийн сайт; аймгийн ИТХ-ын хуудас [www.khural.mn](http://www.khural.mn), байдлын газрын Лед дэлгэц, Дундговь ЗДТГ таныг сонсож “Дундговь Эрх зүйн хөтөч” пэйж болон сум, байгууллагуудын сайт, хуудсуудаар; АВЛЕ.mn программын нийт хэсгээр, байгууллагуудын хэсэгт байрладаг “Цахим мэдээллийн дэлгэц” зэргээр төрийн хаагч болон иргэдэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, хүний хандалттай бөгөөд 451 хүн share хийсэн байна.



цахим Онцгой дэргэдэх аймгийн байна, хуудсууд пэйж Олон үүдний албан 15409

**Хэвлэн олшруулж байрлуулах материал**

Авлигын эсрэг хуулийг сурталчилсан 6 төрлийн тараах материал болох 110 дугаарын сурталчилгаа, Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдэд хориглох зүйл, Авлигын хэлбэрүүд, Авлигын болон хуулийн холбогдох заалтуудаас, Авлигын тухай мэдэгдэх сурталчилгааны материалыг сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг болон иргэд, олон нийтэд 450 ширхэгийг өнгөтөөр хэвлэн олшруулан хүргүүлж, цаашид сум, байгууллагуудыг олшруулан иргэд, албан хаагчдад түгээхийг аймгийн Засаг даргаас үүрэг болгон албан бичгээр хүргүүлсэн. Сум бүрт видео контент, шторк, CD зэргийг тусгайлан хүргүүлж, сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа.



100 хувь

**3.2. Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.**

Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх зорилгоор “Зөв зөвд шударга зөв” сэдэвт соён гэгээрүүлэх аяныг аймгийн ИТХ, ажлын алба, аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ, сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг бүр зохион байгуулан ажиллалаа. Аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нар аяны хүрээнд 15 ажил, арга хэмжээг төлөвлөн баталж шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. “Зөв зөвд Шударга зөв” аяны хүрээнд “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэн авлига,



		<p>ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах-110 сурталчлах, эсрэг тв шторк, теле зохиомж, зураг, зурагт нутгийн хэвлэл хэрэгслээр тогтмол сурталчлах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгууллаа.</p>  <p><b>100 хувь</b></p> <p><b>3.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэх сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.</b></p> <p>“Шударга ёс, хөгжил дэвшилд-110” дугаарын самбарыг төрийн байгууллагууд ажиллуулан, авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан стикерийг аймгийн ЗДТГ-ын Олон нийттэй харилцах үүдэн хэсэгт “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгын хамт байнга байршуулан сурталчиллаа. Уг уриалгыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг дарга, ХХҮГ-ын дарга нар санаачлан төрийн албан хаагчдын оролцоотой “Шударга ёс, хөгжил дэвшилд-110 дугаарыг олон нийтэд хүрээ хэлбэрээр сурталчилж, иргэдийн мэдэх эрхийг дээшлүүлсэн. Уг дугаарыг Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд хэрхэн хамрагдах видео бичлэгт, амьжиргааг дэмжих зөвлөлийн зориулсан гарын авлагын “Малчин өрхийн орлого дэвтрийн хөтөлгөө” зэрэг 5 сумын ЕБС-ийн “Сайн найзууд байцгаая-наалтыг 150ш, ТАХ-чдын хаалганд “Тат түлх” 15 сумын (ГХУС салбар 150 ш түгээн дэлгэрүүлсэн.</p>   <p><b>100 хувь</b></p>
<p><b>Дөрөв. Авлигын эсрэг сургалт байгуулах, хаагчдыг зохион байгуулах сургалтад хамруулах;</b></p>		<p><b>4.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар 01 дүгээр сарын 25-ны дотор АТГ-ын УССГХ-т хүргүүлсэн байх.</b></p> <p>Авлигатай тэмцэх газрын iaac.mn сайтын сургалт бүртгэл хэсэгт Авлигатай тэмцэх газрын сургалтанд хамрагдах нэрсийн жагсаалтад 2 удаа 300, 300 (гурван зуу, гурван зуу) албан тушаалтны мэдээллийг шивж хүргүүлсэн. Мөн тус оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Дундговь, Хөвсгөл аймгийн төрийн байгууллагын албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг сургалт(zoom) буюу Авлига, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөл, Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдэгдэл, тайлбар гаргах, авлигын гэмт хэргийн тухай ойлголт, Эрүүгийн хууль дахь авлигын гэмт хэргийн зохицуулалт зэрэг сэдвүүдээр зохион байгуулагдсан сургалтанд 300 албан тушаалтныг оролцуулж, тэдний Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн</p>

талаар зохих түвшний мэдлэг олгох, өмнө авсан мэдлэгийг баталгаажуулсан үр дүн гарлаа.

**100 хувь**


#### **4.2.АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулсан байх.**

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудад “2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагаа, түүний онцлог”, “2020 оны ХАСХОМ-ийг шинэчлэн мэдүүлэх, цахим системд баталгаажуулах тухай”, “ЭБАТ-ны үйл ажиллагаа, мэдүүлэг гаргагчийн хамрах хүрээ, ХАСХОМ-ийн тайлан мэдээ гаргахад анхаарах зарим асуудал”, “Мэдүүлгийн цахим систем ашиглалт” зэрэг сэдвүүдээр сум, байгууллагуудын салбар 49 ЭБАТ-уудыг анхан болон давтан сургаж чадавхжуулах сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулан тэдэнтэй ярилцлага зохион байгуулан асуусан асуулт, саналыг сонсож 100 хувь хариулт өгч шийдвэрлэн, ЭБАТ-нуудыг орон тоогоор тогтвор суурьшилтай ажиллуулж байна. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан сургалтанд 15 сумын ЗДТГ, ИТХ, 128 байгууллагын 518 удирдлага, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, нягтлан бодогч, Эрх бүхий албан тушаалтан, хэвлэл мэдээллийн ажилтан болон төрийн албан хаагчдыг оролцуулан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжоор тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлсэн үр дүн гарсан.

**100 хувь**

#### **4.3.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан иргэд, хүүхэд залууст хүргэх шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх.**

Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг аймаг, сумдын ЭБАТ болон Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн сургагч багш нар хамтран иргэд, олон нийт, хүүхэд багачуудад цахим хэлбэрээр хүргэх үйл ажиллагааг зохион байгууллаа. Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг сургалт, сурталчилгаа зохион байгуулах сургагч багш бэлтгэх анхан шатны сургалтад аймгийн ИТХ-ын дэргэдэх ГХУСАЗСЗ-ийн нарийн бичгийн дарга, сумдын ИТХ, сургалт хариуцсан хамрагдаж бэлтгэгдсэн. Бэлтгэгдсэн сургагч багш нар болон аймгийн ИТХ, ЗДТГ, ГХУСАЗСЗ хамтран нөөц бололцоогоо ашиглан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 5 хэлтэс, агентлаг, 5 сумын төрийн албан хаагч, иргэд, сурагчдад, сумдын ГХУС салбар зөвлөлийн гишүүд зэрэг нийт 16 нэгжийн 446 хүнд Авлига, авлигын шалтгаан, нөхцөл, хор хөнөөл, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжоор сургалтуудыг зохион байгуулан, сургалтын үеэр суралцагчдыг багт хуваан кэйс ажиллуулан мэдлэгийг зохих түвшинд бататгаж үр дүнг тооцов.



		<p>Олон улсын авлигын эсрэг өдөрт зориулан хүүхэд залуучууд, иргэд, олон нийтийн дунд “Тик ток” уралдаан, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын дунд “АХА” тэмцээнийг зохион байгуулан “Шударга ёс”-ыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудаас зохион байгуулсан бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж түгээн дэлгэрүүлж сурталчлан таниуллаа.</p>  <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p>
<p><b>Тав. Авлигатай тэмцэх газраас эрхийнхээ гаргасан биелүүлэх, хугацаанд нь мэдэгдэх;</b></p>		<p><b>5.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж тайлагнасан байх.</b></p> <p>Авлигатай тэмцэх газрын 2020 онд ирүүлсэн 7 төрлийн зөвлөмжийг хэрэгжүүлэх 18 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж улирал бүр хэрэгжилтийг тооцон Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан комиссар н.Янжинлхамд хүргүүлж, жилийн эцэст 93.3 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байсныг Авлигатай тэмцэх газраас үнэлсэн үнэлгээгээр 85.5 хувийн хэрэгжилттэй үнэлсэн үр дүн гарч, зөвлөмжийн хэрэгжилтээр аймгуудаас дөрөвт жагссан.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>5.2.Мөрдөгчийн мэдэгдлийн хариуг хүргүүлсэн байх.</b></p> <p>Мөрдөн шалгах хэлтсийн II албаны дарга, ахлах комиссар Б.Бат-Олзвой, мөрдөгч, комиссар О.Нармандах нараас тус аймгийн Дэлгэрцогт сумын Засаг дарга М.Баярсүх, аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат нарт ирүүлсэн “Гэмт хэрэг гаргахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулах тухай” мөрдөгчийн мэдэгдлүүдийн хариуг Дэлгэрцогт сумын ЗДТГ-ын дарга С.Нарантунгалагийн 2021 оны 03 дугаар сарын 22-ны 3/119 дүгээр албан бичгээр, Баянжаргалан сумын Засаг дарга Т.Цэвэлмаатай холбоотой мөрдөгчийн мэдэгдлийн хариуг аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 15–ны өдрийн 1/1429 дүгээр албан бичгээр зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг тус тус хугацаанд хүргүүлэн шийдвэрлэсэн.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>5.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнасан байх.</b></p> <p>Тус аймгийн Дэлгэрцогт сумын ЗДТГ-аас байгууллагынхаа удирдлагуудад болон ЗДТГ-ын мэргэжилтэн, албан хаагч нарт Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдн авах тухай хууль, ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах журам, Авлигын эсрэг хууль, Төсвийн тухай хууль, “Хөрөнгө худалдаж авах, олох, зарцуулах журам”-уудыг танилцуулж сургалт зохион байгуулав.</p> <p>Орон нутгийн төсөвт хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдсон асуудлуудад дүгнэлт хийж аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн ГХУСАЗСЗ-өөс тус онд сумдын удирдлага, сумын ГХУС салбар зөвлөлийн гишүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжуудоор сургалт мэдээлэл хийж, гэмт хэрэг гаргахад нөлөөлж буй шалтгаан нөхцөлийн талаар ярилцлага зохион</p>

		<p>байгуулж, цаашид энэ төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авлаа.</p> <p style="text-align: right;"><b>80 хувь</b></p>
	<p><b>Зургаа. Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх;</b></p>	<p><b>6.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байх.</b></p> <p>Авлигын эсрэг нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх зорилгоор “Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нар болон аймгийн Эрх бүхий албан тушаалтнуудаас санаачлан “Дундговь авлигагүй хөгжинө” уриалга гарган хэлтэс агентлаг, сумд, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдөө уриалж нэгдүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. Авлига, ашиг сонирхлын зөрчил, гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан хүрээгээр төрийн албан хаагч бүр сурталчилгаа хийж, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, олон нийтэд сургалт, сурталчилгааны үеэр уг дугаарыг сурталчлан таниулах ажлыг зохион байгууллаа. Олон улсын авлигын эсрэг өдрөөр авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг манлайлан оролцож, авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, төрийн байгууллагын шийдвэрийн илтэд, нээлттэй байдлыг хангах, ялангуяа төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгахад идэвх зүтгэлтэй ажилласан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хамт олон, шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд амжилт гарсан ЭБАТ, Ц.Сувдантуяа, Д.Болорчимэг, Б.Мөнхжаргал нарыг, олон нийтэд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг тайлбарлан таниулах зорилготой “Тик ток” уралдаанд амжилттай оролцож тэргүүлсэн 1-3 байруудыг “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэн ажилласны 1 жилийн ойн арга хэмжээгээр шагнаж урамшууллаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>6.2.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх.</b></p> <p>Улсын төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл арга хэмжээний нийт 25 ажлын гэрээнд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, байгуулж буй гэрээний 15 дугаарт “Захиалагч нь гүйцэтгэгчийн төлөөлөлтэй ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчилтэй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх” гэж гэрээнд тусган хэрэгжүүлж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг тухай бүр гаргаж хэвшүүлээд байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>6.3.Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг цахим хэлбэрээр хянуулж, томилогдсон албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулах.</b></p>



		<p>Тус хугацаанд Нийтийн албанд нэр дэвшсэн 87 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлэн хянуулж, хянуулсан дүгнэлтийг үндэслэн албан тушаалтнуудыг томилсон. Томилогдсон албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд буюу 30 хоногтоо хүлээн авч баталгаажуулах ажлыг зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>6.4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл гаргаж, ЭБАТ цэсний бүртгэлүүдийг бүрэн хөтөлж, дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох.</b></p> <p>Албан тушаалтнууд захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж мэдэгдэл, тайлбарыг албан тушаалтнуудаас 393 удаа гаргаж, ХАСХОМ программын Мэдэгдэл, тайлбар тэдгээрийн шийдвэрлэлтийн бүртгэл хэсэгт зөрчилгүй 355, зөрчилтэй болохоо илэрхийлсэн 38 мэдэгдлийг байршуулан сурталчиллаа.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p>
<p><b>Долоо. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцлийг арилгуулах арга хэмжээ авах;</b></p>		<p><b>7.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.(Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)</b></p> <p>Аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргаас “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг санаачлан хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймаг, сумын ЗДТГ-ын албан тушаалтнуудын өрөө, танхимуудын хаалганд авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчилсан стикерийг байршуулан, 110 дугаарыг сурталчилсан гарын авлагыг олшруулан иргэдэд түгээж, аймгийн ЗДТГ-ын Олон нийттэй харилцах үүдэн хэсэгт “Дундговь авлигагүй хөгжинө”, “110 дугаарын сурталчилгаа”-ны зурагт баннерыг байнга байршуулан сурталчилан ажиллаж байна. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны ERP удирдлагын нэгдсэн системийг үйл ажиллагаандаа байнга ашиглан шат дамжлагыг бууруулан, ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж байна. Аймгийн нэг цэгийн үйлчилгээний танхимд “Гэрэгэ” киоск машиныг суурилуулан ажиллуулж, уг машинаар төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжийг бүрдүүлж, уг төхөөрөмжөөр 320 иргэн 10 төрийн байгууллагын төлбөр хураамжийг төвлөрүүлэн үйлчлүүлсэн байгаа нь төрийн үйлчилгээний шат дамжлага буурч иргэдийн сэтгэл ханамж дээшлүүлсэн үр дүн гарсан.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>7.2.Авлигын шинжтэй буюу сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар Авлигатай тэмцэх газарт мэдээлэх.</b></p> <p>Ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээллийг аймаг хариуцсан мөрдөгч, комиссар О.Нармандахад мэдээлэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p>



		<p><b>7.3.Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг эрх бүхий албан тушаалтанд мэдээлэх.</b></p> <p>Тус онд Хулд сумын Засаг даргаар ажиллаж байсан Ч.Зоригтбаатарыг нийтийн албанд томилогдох эрхийг 3 жил, Гурвансайхан сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны даргаар ажиллаж байсан Ү.Алимааг нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил, Өлзийт сумын Засаг даргаар ажиллаж байсан А.Эрдэнэбатыг нийтийн албанд томилогдох эрхийг 2 жил, Дэлгэрцогт сумын Засаг даргаар ажиллаж байсан Б.Иш-Ёндонг нийтийн албанд томилогдох эрхийг 4 жилээр тус тус хасах ял оногдуулан шийдвэрлэсэн байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>7.4.Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулж мөрдүүлэх.</b></p> <p>Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрмийг аймаг, сумын нийтийн албан тушаалтнуудад нэг бүрчлэн танилцуулан, танилцсан тухайг гарын үсгээр баталгаажуулан, үйл ажиллагаандаа мөрдөж хэвшүүлсэн.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
<p><b>Найм. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах;</b></p>		<p><b>8.1.Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4;</b></p> <p>Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламжаар хийгдэж буй ажил, арга хэмжээ, түүний хуваарилалтыг <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайт болон <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> сайтуудад хуулийн хугацаанд нь тус тус байршуулан олон нийтэд тухай бүр нь мэдээлэх ажлыг хэвшүүллээ.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>8.2.Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4;</b></p> <p>Шилэн дансны мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар сурталчлан таниулах ажлын хүрээнд аймгийн вэб хуудас <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтны нүүрэн хэсэгт Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дүгээр заалтын мэдээллийг бүрэн байршуулсан. Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн дагуу орон нутгийн өмчит төсвийн байгууллага, ОНӨҮГ-ын 142 байгууллага тогтоосон хугацаанд байршуулах нийт 18912 мэдээллээс 86.4 хувь буюу 16340 мэдээллийг хугацаанд нь, 6.5 хувь буюу 1230 мэдээллийг хугацаа хожимдуулж, нийт мэдээлэх мэдээний гүйцэтгэл 90.2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжлээ.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>8.3.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан арга хэмжээг заасан хугацаанд албан ёсны цахим хуудас дээрээ байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах боломжоор хангах.</b></p>

		<p>www.dundgovi.gov.mn сайтын ил тод байдал хэсгийн Үйл ажиллагааны ил тод хэсгийн төсөл хөтөлбөр цэсэнд гадаадын хөрөнгөөр хийгдэж буй 9 төсөл арга хэмжээ, тусгай зөвшөөрөл хэсэгт “Архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл” олгосон болон хүчингүй болсон 5 захирамж, уул уурхайн тусгай зөвшөөрлийн бүртгэл, бодлого, шийдвэрт 6 дэд хөтөлбөр, бизнес эрхлэгчдийг дэмжих жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө, хэрэгжилт, төсөв санхүү хэсэгт 2021 оны орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг баталсан ИТХ-ын тогтоол, явцын мэдээллийг тус бүр байршуулж иргэд, олон нийтийг мэдээ, мэдээллээр нээлттэй ил тод ханган ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> 
<p>Ес. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх;</p>		<p><b>9.1.Төсөв, санхүүгийн тайланг сар, улирал жилээр хугацаанд нь гаргаж холбогдох дээд байгууллагад тайлагнах.</b></p> <p>Төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 02-ны дотор гаргаж холбогдох дээд байгууллагад хянуулан тайлагнадаг бөгөөд улирлын мэдээг дараа сарын 03-ны дотор гаргаж, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 10-ны дотор цахим тайланд тайлагнан ажиллаж хэвшээд байна.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.2.Тухайн жилийн төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор байршуулах.</b></p> <p>2021 оны жилийн батлагдсан төсвийн мэдээллийг 1 сарын 10-ны дотор shilendans.gov.mn сайтын бүтэн жилээр мэдээлэл оруулах хэсэгт загвар хүснэгтэн мэдээллээр байршуулж, файлаар хавсарган харуулсан болно.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.3.Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг 4 дүгээр сарын 1-ний дотор байршуулах.</b></p> <p>2020 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг хугацаанд нь shilendans.gov.mn сайтанд байршуулсан болно.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.4.Сарын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 8-ны дотор байршуулах.</b></p> <p>2021 оны 1-11 дүгээр сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 08-ны дотор shilendans.gov.mn сайтын “сар бүр оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон файлаар хавсарган 9 удаагийн давтамжтайгаар хугацаанд нь байршуулаад байна.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.5.Улирлын төсвийн гүйцэтгэлийг дараа сарын 8-ны дотор байршуулах.</b></p> <p>Тус оны I, II, III дугаар улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 8-ны дотор shilendans.gov.mn сайтын “улирал бүр оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг файлаар хавсарган байршуулаад байна.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.6.Хагас жилийн төсвийн гүйцэтгэл.</b></p> <p>Тус оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 8-ны дотор shilendans.gov.mn сайтын “хагас жил</p> 

оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг файлаар хавсарган байршуулаад байна.

**100 хувь**

**9.7.Хагас жилийн санхүүгийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор байршуулах.**

Тус оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь shilendans.gov.mn сайтын “хагас жил оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг файлаар хавсарган байршуулаад байна.

**100 хувь**

**9.8.Дараа жилийн төсвийн төслийг 8 дугаар сарын 15-ны дотор байршуулах.**

2022 оны төсвийн төслийг хугацаанд нь shilendans.gov.mn сайтын “хагас жил оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг файлаар хавсарган байршуулаад байна.

**100 хувь**


**9.9.Жилийн эцсийн санхүүгийн тайланг 5 дугаар сарын 1-ний дотор байршуулах.**

2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хугацаанд нь shilendans.gov.mn сайтын “бүтэн жилээр оруулах мэдээлэл” хэсэгт файл хэлбэрээр байршуулсан.

**100 хувь**

**9.10.Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 5 дугаар сарын 1-ний дотор байршуулах.**

2020 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайланг хугацаанд нь shilendans.gov.mn сайтын “бүтэн жилээр оруулах мэдээлэл” хэсэгт файл хэлбэрээр байршуулсан.



**100 хувь**

**9.11.Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар мэдээлэх (өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт багтааж мэдээлэх)**

Төсөвт орсон өөрчлөлтийг хугацаанд нь shilendans.gov.mn сайтын “тухай бүр оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон файлаар хавсарган байршуулаад байна.

**100 хувь**

**9.12.Төсвийн орлого бүрдүүлэлтийг нээлттэй болгож (Татварын орлого, татварын бус орлого) мэдээлэх.**

Татварын орлого, татварын бус орлогыг shilendans.gov.mn сайтад хугацаанд байршуулав.

**100 хувь**

**9.13.Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтыг тайлагнах (Бүтэн жилээр, хагас жилээр)**

Засгийн газрын 2014 оны 12 сарын 15-ны өдрийн 384-р дугаар тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 4 дэх зүйлийн 4.1.8 дэх заалт “Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт”-ын хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор “хагас жил оруулах мэдээлэл” хэсэгт хугацаанд нь байршуулав.


**100 хувь**

		<p><b>9.14.Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)-г мэдээлж байршуулах.</b></p> <p>2021 оны 1-11 дүгээр сарын цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлого зарлагын мэдээг дараа сарын 08-ны дотор shilendans.gov.mn сайтын “тухай бүр оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэл болон дагалдах баримт бичгийг файл хэлбэрээр 11 удаагийн давтамжтайгаар хугацаанд нь байршуулав.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.15.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр)-ийг байршуулж мэдээлэх.</b></p> <p>Тухайн сард өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн хэрэгжилтийг дараа сарын 08-ны дотор shilendans.gov.mn сайтын “тухай бүр оруулах мэдээлэл” хэсэгт хүснэгтэн мэдээлэлээр харуулдаг бөгөөд холбогдох тушаал, захирамжийг pdf хэлбэрээр дагалдах файлаар хавсаргадаг болно. 2021 оны 1-11 дүгээр сарын мэдээллийг нийт 11 удаа хугацаанд нь мэдээллээ.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>9.16.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилт, явц байдлын талаарх мэдээллийг мэдээлэх.</b></p> <p>Эрчим хүчний яамнаас “10 аймгийн төвийн дулааны станц барих төсөл”, Азийн хөгжлийн банкны хөрөнгөөр аймгийн төвд цэвэрлэх байгууламжийн ажил, Эрдэнэдалай сумын усан хангаж, ариутгах татуургын шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийн ажил, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд 6 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөгжлийн төвийг барих, Япон Улсын Засгийн газрын 2021 оны Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хүрээнд “Дундговь аймгийн Сайнцагаан сумын 3-р цэцэрлэгийн засвар”-ын ажлын Дэлхийн банкны санхүүжилттэй “Эрчим хүчний төсөл-2” ажлын хүрээнд БЗӨБЦТС ТӨХК-ийн харьяа Дундговь Цахилгаан түгээх сүлжээ салбарт хэрэгжүүлэх “Дундговь аймгийн төвийн 6кВ ба 0.4кВ хүчдэлийн түгээх сүлжээг шинэчлэх, цахилгаан хангамжийг сайжруулах ажил”-ын угсралтын ажил, Зах зээл бэлчээрийн удирдлага хөгжил төслийн хүрээнд аймгийн төвд хүнсний ногооны зоорь, өвс, тэжээлийн агуулах саравч, борлуулалтын цэгийн барилгын угсралтын ажил зэрэг хийгдэж буй төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл, түүний хэрэгжилт, явцын мэдээллийг тухай бүрт dundgov.gov.mn сайтны Ил тод байдал хэсгийн төсөл хөтөлбөр талбарт байнга байршуулан иргэд, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
	<p><b>Арав. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах;</b></p>	<p><b>10.1.Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах (Тухай бүр шинэчилсэн байх)</b></p> <p>Төрийн албаны удирдах албан тушаалын давхардсан тоогоор 17, гүйцэтгэх албан тушаалын дэс түшмэлийн албан тушаалын сул орон тооны давхардсан тоогоор 91 албан тушаал, туслах түшмэлийн 43 сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлж шалгалтыг 2021 оны 1, 10 дугаар саруудад зохион байгуулж, шалгалтаар 49 ажлын байр</p>

		<p>нөхөгдлөө. Дээрх 151 ажлын байрны зарыг <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайтны ТАСЗөвлөл талбар, Төрийн албан зөвлөлийн <a href="http://csc.gov.mn">csc.gov.mn</a>-д байршуулан сурталчилж, иргэдийг мэдээлэл авах боломжийг бүрэн бүрдүүлж ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>10.2.Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмын хэрэгжилтийг хангах.</b></p> <p>Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж 2021 онд хийж хэрэгжүүлэх 240,0 сая төгрөгний төсөвтэй 8 төрлийн үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг 90 хувийн гүйцэтгэлтэй ханган ажиллалаа. <a href="http://Dundgovi.gov.mn">Dundgovi.gov.mn</a> сайтад “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг байршуулан орон нутгийн иргэд, хөдөлмөрчдийг энэ талаарх мэдээлэл авах боломжийг бүрдүүлэн орон нутагт зайлшгүй шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн салбарт суралцаж буй төгсөх курсийн 35 оюутанд нийт 70,6 сая төгрөгийн, Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтад албан хаагчдыг үе шаттай хамруулж, эрүүл мэндийн салбарын 7 албан хаагчид магистрын сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлж, хамтын ажиллагааны гэрээ байгуулав. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Нэгдсэн эмнэлгийн Дотор, дотоод шүүрлийн булчирхайн их эмч Ч.Уранбайгаль, “Цэгц билиг” сургуулийн Монгол хэл, бичиг уран зохиолын багш М.Ганбагана нарт тус бүр 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Орон нутгийн удирдлагуудад “Хүний нөөцийн төлөвлөлт ба үр дүн”, “Цаг хэд болж байна”, “Удирдлагын хамтын ажиллагааны манлайлал” сургалтуудыг тус тус зохион байгуулан 175 албан хаагчдыг чадавхжууллаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>10.3.Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тухай бүр ил тод, нээлттэй мэдээлэх.</b></p> <p>Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 24-ний А/383 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог Төсвийн тухай хуулийн 14.2.12, МУЗГ-ын 2016 оны 8 дугаар сарын 9-ний өдрийн 09 дүгээр тогтоолыг үндэслэн УТ-2, ТЗ-34, ТТ-3, ТҮ-25 орон тоотойгоор баталж, <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайтны Хүний нөөцийн талбар хэсэгт байршуулав.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
	<p><b>Арван нэг. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох;</b></p>	<p><b>11.1.Ажилтнуудын хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээлэл, албан тушаалын тодорхойлолтыг мөрдүүлэх.</b></p> <p>Төрийн албаны зөвлөлөөс баталсан албан тушаалын тодорхойлолтыг албан хаагчдад мөрдүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж, албан хаагч бүрийн хариуцсан ажил, албан тушаалын зорилт, ажлын чиг үүргийн талаарх мэдээллийг <a href="http://Dundgovi.gov.mn">Dundgovi.gov.mn</a> сайт болон ERP мэдээллийн цахим сайтад байршуулан ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>11.2.Төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээлэл.</b></p> <p>Аймаг, сумдын Засаг дарга нар Бямба гараг бүр 11:00-17:00 цагт иргэд, олон нийтийг тусгайлан нэг бүрчлэн хүлээн авч уулзах уулзалт зохион байгуулан, тэднээс дэвшүүлсэн санал бодлыг аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлэх, зарим хугацаатай асуудлыг хуулийн хугацаанд</p>

		<p>шийдвэрлэх ажлыг хэвшүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрууд санал хүсэлт хүлээн авах нээлттэй утсыг тогтмол ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар 7059-106 утсаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, тус нээлттэй утсыг цахим сайт, фэйсбүүк хуудас, мэдээллийн самбар зэрэг бүхий л хэлбэрээр сурталчлан таниулж байна. Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулах ажилд аймгийн ИТХ-ын Төлөөлөгч болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан боловсруулсан нь иргэд, олон нийтээс гаргасан санал санаачлагыг төрийн бодлогод тусган хэрэгжүүлж буй үр дүн гарлаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
<p><b>Арван хоёр. Иргэдийн өргөдөл (санал,мэдэгдэл) гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах;</b></p>		<p><b>12.1.Өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)</b></p> <p>Тус аймгийн нийт төрийн байгууллага, 15 сумд иргэдээс санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг бичгээр, цахимаар, утсаар, хайрцагаар, биечлэн уулзах хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэж хэвшсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 25,779 өргөдөл бүртгэснээс 25,609 өргөдлийг хуулийн хугацаанд судлаж 99,3 хувийн гүйцэтгэлтэй шийдвэрлэлээ. Аймаг, сумдын Засаг дарга нар Бямба гараг бүр 11:00-17:00 цагт иргэдтэй тусгайлан уулзалт хийж, иргэдийн санал бодлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэж байна. Иргэдээс санал, хүсэлт хүлээн авах бүх сувгийг идэвхжүүлсэн хэдий ч иргэдээс утсаар, бичгээр ирүүлсэн санал, хүсэлт нийт өргөдлийн 94,9 хувийг эзлэж байна. Агентлаг, сумдад санал хүсэлт хүлээн авах нээлттэй утас тогтмол ажиллуулж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газар 7059-106 утсаар иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, тус нээлттэй утсыг цахим сайт, фэйсбүүк хуудас, мэдээллийн самбар г.м бүхий л хэлбэрээр иргэдэд сурталчилж байна. Мөн сумдад IP технологид суурилсан, иргэд цээжлэхэд хялбар дугаар бүхий утсыг тогтмол ажиллуулж эхлээд байна.</p> <div data-bbox="1268 884 1524 1243" style="border: 1px solid black; padding: 5px;"> <p style="text-align: center;"><b>СУМДЫН ИРГЭДЭЭ СОНХОХ НЭЭЛТТЭЙ УТАС</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Адаацаг - 7507-8787</li> <li>2. Баянжаргалан - 7507-9911</li> <li>3. Говь-утгаал - 7507-8393</li> <li>4. Гурвансайхан - 7505-4949</li> <li>5. Дэлгэрцогт - 7509-6611</li> <li>6. Дэлгэрхангай - 7507-5959</li> <li>7. Дэрэн - 7505-8787</li> <li>8. Луус - 7509-6959</li> <li>9. Өлзийт - 7533-7700</li> <li>10. Өндөршил - 7505-3636</li> <li>11. Сайхан-Овоо - 7505-4499</li> <li>12. Сайнцагаан - 7533-5959</li> <li>13. Хулд - 7533-4949</li> <li>14. Цагаандэлгэр - 7577-5959</li> <li>15. Эрдэнэдалай - 7511-9959</li> </ol> </div> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>12.2.Дотоод ажил, санал, өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг ил тод, нээлттэй байршуулах.</b></p> <p>Дотоод ажил, өргөдөл, гомдол, санал хүсэлт хариуцсан албан хаагчийн мэдээллийг өрөөний хаягжуулалт болон байгууллагын мэдээллийн самбарт тогтмол байршуулсан. dundgovi.gov.mn аймгийн цахим сайтад санал хүсэлт хүлээн авах албан хаагчийн мэдээлэл, Төрийн байгууллага албан тушаалтанд иргэдээс ирүүлсэн өргөдлийг хүлээн авч, шийдвэрлэх журам, аймаг, сумдын Засаг дарга нарын иргэдийг хүлээн авч уулзах журам, цагийн хуваарийг өрөө танхимын мэдээллийн самбар болон цахимаар иргэдэд сурталчлан таниулж ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>12.3.Иргэдийн өргөдөл гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх.</b></p>

		<p>Аймгийн хэмжээнд өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн явцын мэдээг 14 хоног тутам нэгтгэн Засаг даргын шуурхай хуралдаанд танилцуулан, анхаарч сайжруулах зүйлсийг залруулан ажиллаж хэвшээд байна. 2020 оны мөн үетэй харьцуулахад өргөдөл гомдлын тоо 1,5 дахин нэмэгдсэн хэдий ч судлаж шийдвэрлэсэн гүйцэтгэл 99,3 хувьтай байна. Өргөдөл гомдол хүлээн авах, бүртгэх, судлаж, шийдвэрлэх явцад тогтмол хяналт тавьж ажилласны үр дүнд нэг өргөдлийг судлаж шийдвэрлэх дундаж хугацаа 2020 онд 41 хоног байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар байдлаар нэг өргөдлийг судлаж шийдвэрлэх дундаж хугацаа 27,7 хоног болж даруй 13,2 хоногоор багассан байна. Мөн иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн улирлын тайланг аймгийн цахим сайт болон фэйсбүүк хуудсаар иргэдэд мэдээллэн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p>
	<p><b>Арван гурав. Тусгай зөвшөөрлийн мэдээллийг ил нээлттэй болгох;</b></p>	<p><b>13.1.Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл)-ийг ил тод, нээлттэй байршуулах.</b></p> <p>Тус хугацаанд эрүүл мэнд, боловсрол, уул уурхайн болон согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох ажлын хэсгүүд хуралдаж тусгай зөвшөөрлийг сунгах буюу шинээр олгосныг <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайт болон Эрүүл мэндийн газрын <a href="http://du.mohs.gov.mn">du.mohs.gov.mn</a> сайтад тухай бүрт нь ил тод, нээлттэй байршуулан сурталчиллаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>13.2.Дээрх зөвшөөрөл (тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл)-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг ил тод, нээлттэй байршуулах.</b></p> <p>Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх, Эрүүл мэнд, боловсролын тусгай зөвшөөрөл олгох, сунгуулахад, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, барилга байгууламжийн ашиглалтад оруулах, улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэж буй ажил, бараа, зөвлөх үйлчилгээний бүрдүүлэх материалын жагсаалт, журмыг <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайтны Ил тод байдал хэсгийн үйл ажиллагааны ил тод байдалд, Эрүүл мэндийн яамны <a href="http://mohs.mn">mohs.mn</a>, Эрүүл мэндийн газрын <a href="http://du.mohs.gov.mn">du.mohs.gov.mn</a> сайтад Эрүүл мэндийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын тушаал, журам тусгай зөвшөөрөл олгох болон сунгахад шаардлагатай материалын жагсаалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг ил тод, нээлттэй байршуулан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>13.3.Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг ил тод, нээлттэй байршуулах.</b></p> <p>Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс тус онд 4 удаа хуралдаж 8 сумын Эрүүл мэндийн төвийн сунгалтыг/5 жил/, 3 хувийн эмийн сан/3 жил/, 3 шүдний эмнэлэг/5 жил/, 3 сувилал/5 жил/, Нэгдсэн эмнэлэг/5 жил/, Хүүхдийн 2 хувийн эмнэлэг/5 жил/, 3</p>

		<p>ариутгал халдваргүйтэлийн үйлчилгээнд/3жил/, Дотор зүрх судасны хувийн эмнэлэг/3 жил/, Уламжлалт өвчний оношилгоо, эмчилгээний эмнэлэгт 3 жилээр тус тус хугацааг сунгах буюу шинээр тусгай зөвшөөрөл олгож ажилласан.</p> <p>2020 оны ХХААХҮС-ын А/277 дугаар “Норматив тогтоох тухай” тушаалаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цэгийн тоог аймаг, нийслэл, суманд 1000 хүн ам тутамд 4 хүртэл байхаар тогтоосон. 2021 онд тусгай зөвшөөрлийн эрхийг сунгуулахаар 18, шинээр авахаар 17 аж ахуйн нэгж байгууллага саналаа ирүүлснээс 32 зөвшөөрлийг /шинээр 12, сунгасан 18, сэргээсэн 1, хүчингүй болгосон 5/ хэлэлцэн шийдвэрлэлээ. Нийт тусгай зөвшөөрлийн тоо 130 болж өмнөх оноос 9-өөр нэмэгдсэн. Энэ нь шинээр байгуулагдсан стандартын шаардлагад нийцсэн худалдаа үйлчилгээний байгууллага байгаа болно. Цаашид стандартын шаардлагад нийцээгүй болон холбогдох хуулийн зөрчил гаргасан худалдаа үйлчилгээний газрын тусгай зөвшөөрлийн эрхийг хүчингүй болгож тоог цөөрүүлэхээр зорьж байна. Тусгай зөвшөөрлийг шийдвэрлэсэн захирамжийг, <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайтны Ил тод байдал талбарт байршуулан сурталчиллаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p>
<p><b>Арван дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах;</b></p>	<p><b>14.1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах.</b></p> <p>2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдөр аймгийн Засаг дарга батлан, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн 2021 оны 05 дугаар сарын 05-ны 02 дугаар тогтоол, 08 дугаар сарын 06-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор өөрчлөлт тодотгол хийгдэж төлөвлөгөөнд тухай бүр өөрчлөлтийг хийж олон нийтэд аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a>, төрийн худалдан авах ажиллагааны <a href="http://tender.gov.mn">tender.gov.mn</a> цахим системд нийтэлж ил тод байдлыг ханган ажилласанаас гадна орон нутгийн 7 хоног тутмын хэвлэл “Дундговийн амьдрал” сонины 2021 эхний дугаарт нийтлүүлэн ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>14.2.Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан.</b></p> <p>2020 худалдан авах ажиллагааны тайлан, Мандалговь хотын 5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбайн ажил, 5, 12-р байрны фасадны ажил, аймгийн төвийн авто замын засвар, хурд сааруулагчийн ажил болон Эрдэнэдалай сумын ЗДТГ-ын барилгын засварын ажлуудад хийсэн дотоод аудитын тайланг <a href="http://dundgovi.gov.mn">dundgovi.gov.mn</a> сайтын Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаа хэсэгт зөвлөмжийн хэрэгжилттэй тус тус тайлагнаж мэдээллийг байршуулсан.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>14.3.Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам (тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт) тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулах.</b></p>	 

Тендер шалгаруулалт улсын хэмжээнд 2017 оноос хойш tender.gov.mn цахим системээр цахим хэлбэрээр зохион байгуулах боломжтой болсон бөгөөд Дундговь аймагт 2018 оноос хойш төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа бүх байгууллагууд бүх тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр зарлан зохион байгуулж байна. Цахим тендерийн давуу тал нь оролцогч цаг хугацаа, орон зайн хамааралгүй тендерийн урилга, тендерийн баримт бичиг, шалгуур үзүүлэлт, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ажлын зураг, төсөв, техникийн тодорхойлолтыг үнэ төлбөргүй татан авах боломжоор хангагдаад байна. Дундговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд 2021 оны 11 дүгээр сарын байдлаар дахин зарласан тендерийг оролцуулан нийт 284 тендер шалгаруулалт зохион байгуулсанаас Орон нутгийн өмчийн газарт 70 тендер зарлан зохион байгуулагдсан.



100 хувь

**14.4.Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийг цахим хуудсанд байршуулах.**

Тендер шалгаруулалт шилжсэнтэй холбоотойгоор тендерт оролцогчийн шалгарсан болон шалгараагүй талаарх мэдээллийг tender.gov.mn системийн “Тендер шалгаруулалтын үр дүн” хэсэгт тухайн бүр үндэслэлийн хамт оролцогчид хүргэгдэж буй хариу мэдэгдлийн хуулбарыг оруулан ажиллаж хэвшээд байгаа бөгөөд оролцогчид ч шалгарсан оролцогчийн ирүүлсэн тендерийг хянах боломжоор бүрэн хангагдсан.

ТЕНДЭР	Төлбөр	Төлбөр	Төлбөр	Төлбөр
1. Өрхийн байгууллагууд	8,000,000	100%	100%	100%
2. Өрхийн байгууллагууд	10,000,000	100%	100%	100%
3. Өрхийн байгууллагууд	10,000,000	100%	100%	100%
4. Өрхийн байгууллагууд	10,000,000	100%	100%	100%

100 хувь

**14.5.Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг цахим хуудсандаа байршуулах.**

dundgovi.gov.mn сайтын утасны жагсаалт цэсэнд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн жагсаалтыг байршуулж, тухай бүр тус жагсаалтыг шинэчилэн ажиллаж байна.




100 хувь

**14.6.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл.**

2021 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 2021 оны төсвийн тодотголоор шинэчлэн батлуулж,

		<p>нийт 44 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөснөөс 43 төсөл арга хэмжээний гэрээ хийгдээд байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>14.7.Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө гүйцэтгэх.</b></p> <p>Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 2021 оны төсвийн тодотголоор шинэчлэн батлуулж, нийт 32 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөснөөс 29 төсөл арга хэмжээний гэрээ хийгдээд байна.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p>
<p><b>Арван тав. эсрэг санаачилгыг ажиллах;</b></p>	<p><b>Авлигын санал дэмжин</b></p>	<p><b>15.1.Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг (А3) гэрчилгээ олгох хүний нөөцийг бэлтгэх.</b></p> <p>Худалдан авах ажиллагааны мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх цахим сургалтыг 2021 оны 3 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд Худалдан авах ажиллагааны сургалт зөвлөгөө өгөх төв ТББ-тай хамтран 161 хүнд зохион байгуулсан бөгөөд тус сургалтаар хамрагдсан 161 хүн цахим шалгалтанд орж 48 хувь буюу 78 хүн тэнцэж, нийт сертификат эзэмшигчийн тоо 187 болж, худалдан авах ажиллагаанд иргэд, ТББ-ын төлөөллийг оролцуулж буй үр дүн гарсан.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>15.2.Шилэн дансны хуулийн хэрэгжилт, шилэн дансны мэдээллийг иргэд, олон нийтэд сурталчилж хандалтыг нэмэгдүүлэх.</b></p> <p><a href="http://www.dundgovi.mn">www.dundgovi.mn</a> сайтны нүүрэн хэсэгт Шилэн дансны мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй байршуулан сурталчилж, иргэдийн хандалтыг нэмэгдүүлэх ажлыг улирал бүр зохион байгуулан сурталчлан таниулах ажлыг Санхүүгийн хяналт, аудитын албанаас зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>15.3.Өвлийн хүлэмж, Хүндэтгэлийн өргөө, Сүм хөх бүрд, аймгийн ЗДТГ-ын өмчлөлийн орон сууцны гэрээнүүдийг шинэчлэн байгуулж, түрээсийн төлбөрийг хуулийн хугацаанд төвлөрүүлж байх.</b></p> <p>Өвлийн хүлэмж, Хүндэтгэлийн өргөө, Сүм хөх бүрд зэрэг газруудын гэрээг шинэчлэн байгуулж, байнгын хараа хяналттай болгон эзэнжүүлж, аймгийн ЗДТГ-ын өмчлөлийн орон сууцыг ашиглах, эзэмших журмыг шинэчилж, тус газрын албан хаагчдын дунд хэлэлцүүлэг зохион байгуулан түрээсийн төлбөрийг бүрэн төлүүлэх, аймгийн ЗДТГ-т ажилладаггүй болон өндөр настны тэтгэвэр тогтоолгосон иргэнд ашиглуулахгүй байхаар шийдвэрлэн мэдэгдэл өгсөн.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p> <p><b>15.4.”Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэн, авлигын эсрэг ОУ-ын өдрийг иргэд, албан хаагч, ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулан, авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг сурталчлах.</b></p> <p>“Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлэх хүрээнд хүүхэд, залуучууд, иргэдийн дунд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг тайлбарлан таниулах “Тик ток” уралдаан,</p>




		<p>аймгийн удирдах албан тушаалтнуудын дунд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлах “АХА” уралдаант танин мэдэхүйн тэмцээнийг тус тус зохион байгуулан, тус өдрөөр шударга ёсыг түгээн дэлгэрүүлсэн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулав. Авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг аймгийн Засаг даргаас санаачлан сурталчилж, тус аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын төрийн албан хаагч бүр сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд иргэдийн хандалт, нэгдэх үйл ажиллагаанууд тасралтгүй зохион байгуулагдсан.</p> <p style="text-align: right;"><b>100 хувь</b></p> <p><b>15.5.Газар, хэлтэс, агентлаг сумд Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хүрсэн үр дүнг тодорхойлж, холбогдох зөвлөл, хурлаар хэлэлцүүлэн үнэлүүлж, нотлох баримттай Хууль, эрх зүйн хэлтэст 6, 12 дугаар сарын 5-ны дотор ирүүлэх.</b></p> <p>Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 6 хэлтэс, агентлаг, 6 сум Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлж тайлагнасан бол 16 хэлтэс, агентлаг, 9 сумын ЗДТГ хугацаа хоцроосон буюу одоогоор огт ирүүлээгүй болно.</p> <p style="text-align: right;"><b>70 хувь</b></p>
9.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>-“Зөв зөвд, шударга зөв” аяны хугацаанд аймгийн ИТХ-ын дарга болон аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-ын төлөөлөгч, хэлтэс, агентлагийн удирдлагуудыг уриалан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх <b>“Дундговь авлигагүй хөгжинө”</b> уриалгад нэгдсэн үйл ажиллагааг хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ үргэлжлүүлэн зохион байгуулан нэгдэж, иргэд, олон нийтэд уриалгаа сурталчлан таниулж ажиллалаа.</p> <p>-Авлига, ашиг сонирхлын зөрчил, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээлэл хүлээн авах 110 дугаарыг аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын төрийн албан хаагч бүр сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулсны үр дүнд иргэдийн хандалт, нэгдэх үйл ажиллагаанууд тасралтгүй зохион байгуулагдаж ирсэн.</p> <p>-Хүүхэд, залуучууд, иргэдийн дунд авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг тайлбарлан таниулж, авлигын эсрэг үйлсэд дуу хоолойгоо нэгтгэж, хүсэл зоригоо илэрхийлэх зорилготой “Тик Ток”, Гар зургийн уралдаануудыг зохион байгуулж сурталчилсан.</p> <p>-Аймгийн хэмжээний Нийтийн албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн ажил эрхлэлтийн судалгааг шинэчлэн, 36 хэлтэс агентлаг, сумдын 379 хамаарлыг тогтоож, <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a> сайтад ил тод сурталчилсан нь иргэдээс удирдлагуудын томилгоонд хяналт тавих нөхцлийг бүрдүүлсэн үйл ажиллагаа болов. Уг судалгааг Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалтаар ХАСУМ хянуулахад хэрэгтэй, ажил хэрэгч асуудал гэж үзэн улсын хэмжээнд туршлага болгон хэрэгжүүлсэн. Тус судалгааг аймгийн <a href="http://www.dundgovi.gov.mn">www.dundgovi.gov.mn</a></p> 

сайтны нүүрэн хэсгийн Авлигын эсрэг үйл ажиллагаа хэсэгт ил тод байршуулж, сум, байгууллагууд удирдах албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдол бүрт шинэчилж байхыг ЭБАТ-нуудад зөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

-ХАСУМ хянуулсан тухай дүгнэлт(албан бичиг)-ийг аймгийн [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсгийн ХАСУМ хянуулсан дүгнэлт хэсэгт тухай бүр байршуулан ил тод нээлттэй сурталчилах ажлыг хэвшүүлсэн.

-Хүүхэд, залуучуудад зориулж уриалсан нөлөөллийн тв шторкийг бэлтгэж [www.dundgovi.gov.mn](http://www.dundgovi.gov.mn) болон бусад төрийн байгууллагуудын цахим хуудсуудаар сурталчиллаа.



-Улсын болон орон нутгийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлын гэрээ байгуулж буй компаниудад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдэгдэл тайлбар гаргахыг гэрээнд тусган хэрэгжүүлж байна.

-Тендер шалгаруулалтын үнэлгээний хороо хуралдах бүртээ үнэлгээний хорооны гишүүдийг авлигын эсрэг уриалсан энгэрийн тэмдэг хэрэглэж хэвшүүлснээр, тендерийг шударгаар үнэлж шалгаруулах орчныг бүрдүүлэв.

-Аймгийн Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн 2018 оны 16 дугаар хурлаар “Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, гэрээний төслийг хянах, баталгаажуулах, сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн дарга нарын баталсан эрх зүйн актыг хянах, зөвлөх журам”-ын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Захиргааны актад санал өгч, хянах албан тушаалтнууд “Ашиг сонирхлын зөрчилтэй, зөрчилгүй эсэхээ илэрхийлэхийг зааж өгсөн.

-Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, шторк, FM радиогийн зөвлөгөө, мэдээллийг аймаг, сум, байгууллагуудын сайт, пэйж хуудсуудаар иргэд, олон нийтэд хүргэх ажлыг аймаг, сум, хэлтэс, агентлагуудын Эрх бүхий албан тушаалтнууд болон хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан бүр оролцож олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.



-“Зөв зөвд шударга зөв” аяны хүрээнд “Дундговь авлигагүй хөгжинө” уриалгыг хэрэгжүүлж, тайлант хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа аймгийн удирдлагууд болон иргэд олон нийт, хүүхдүүдийг оролцуулан Олон улсын авлигын эсрэг өдөр дүгнэн, тайланг хэлэлцүүлж тэмдэглэн өнгөрүүллээ.

-Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд улс, орон нутгийн төсвөөс хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллахыг анхаарах.

-Хууль бус шийдвэрээр ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн тохиолдолд буруутай албан тушаалтнаас хохирол барагдуулах ажлыг эрчимжүүлэх.

-Авлигатай тэмцэх газрын болон Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлж ажиллах. (Төрийн жинхэнэ албан хаагчийн томилгооны асуудалд иргэд, олон нийтийн хяналтыг сайжруулах)

-Аймгийн Засаг даргын нөөц санг зориулалтын дагуу зарцуулах.

			-“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй ойлгомжтой хэлбэрээр байршуулах нөхцлийг бүрдүүлэх.				
11.	Шаардагдах төсөв		10.000.000				
12.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		-Аймгийн ЗДТГ-ын Эрх бүхий албан тушаалтан буюу авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны орон тоо ажилтантай болгох. -Худалдан авах ажиллагаанд байнгын хяналт тавьж, АЗ сертификатын сургалтыг үнэ төлбөргүй, ялангуяа иргэд, ТББ-ын төлөөллийг үнэ төлбөргүй сургалтанд өргөн хүрээгээр оролцуулж, үнэлгээний хороонд тогтмол ажиллуулах. -Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэгч сургагч багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулж, хамтран ажиллахад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх.				
13.	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо		518				
14.	Бүх шатны төрийн байгууллагад хамаарах						
			Зорилго 1	Зорилго 2	Зорилго 3	Зорилго 4	Зорилго 5
			100.0	85.0	100.0	90.0	80.0
15.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилго 6	Зорилго 7	Зорилго 8	Зорилго 9	Зорилго 10
			85.0	85.0	100.0	100.0	90.0
			Зорилго 11	Зорилго 12	Зорилго 13	Зорилго 14	Зорилго 15
16.			100.0	90.0	100.0	95.7	76.0
17.	Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ		Нэгдсэн үнэлгээ				
			91.7 хувь				

ХЭРЭГЖИЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН /С.ЦЭНГЭЛМАА/

ХЯНАСАН: АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХУУЛЬ,  
ЭРХ ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Л.БАЯРСАЙХАН/

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА /Г.САМДАНЦООДОЛ/